

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 66.7 хувьтай  
хэрэгжсэн байна.

### АУДИТЫН КОД: ГСА-2026/05-6-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудитор:  
Б.Сарантуяа, Утас: 70543179  
Цахим хаяг: [Sarantuyab@audit.gov.mn](mailto:Sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр,  
Утас:70543179  
Цахим хаяг: [Naranbayarg@audit.gov.mn](mailto:Naranbayarg@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179  
Цахим хаяг: [darkhanbatb@audit.gov.mn](mailto:darkhanbatb@audit.gov.mn)

Чойр хот

2026 он

**Тайланг бэлтгэсэн:**

Говьсүмбэр аймаг  
дахь Төрийн аудитын  
газар

Дарга, тэргүүлэх  
аудитор

Б.Сарантуяа

Аудитын менежер

Г.Наранбаяр

Ахлах аудитор

Б.Дарханбат

Аудитор

С.Батцэцэг

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70543179 дугаарын  
утсаар харилцана уу.

**ХАЯГ:**

Сүмбэр сум 3-р баг,  
Нутгийн удирдлагын  
ордон, 206 тоот

2026 оны 05 дугаар сар

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна. 8

- 1.1. ОНХО-р хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь бодлогын зорилтод нийцэж байгаа боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй бүрэн нийцээгүй, ТАХ-г шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж эрэмбэлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. .... 8
- 1.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй 8 төсөл, арга хэмжээ баталсан байна. .... 9

Зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг бодитой тооцож төлөвлөөгүй нь худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл учруулж байна. 11

- 2.1 Тендер шалгаруулалтын аргыг хуульд нийцүүлэн сонгосон боловч зарим төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, төсөвт өртгийг бодитой тооцож батлуулаагүй байна. .... 11
- Б.2 Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авсан байна. .... 14

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 66.7 хувьтай хэрэгжсэн байна. 14

- В.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна. .... 14
- В.2 Ашиглалтад хүлээн авсан 532.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг бүртгэж тайлагнаагүй байна. .... 18

Дүгнэлт

Зөвлөмж

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлангийн хавсралт

ТОВЧИЛСОН ҮГС

<b>ААНБ</b>	<b>Аж ахуй нэгж байгууллага</b>
<b>ААТҮГ</b>	<b>Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</b>
<b>АДБОУС</b>	<b>Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт</b>
<b>АИТХ</b>	<b>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</b>
<b>ГА</b>	<b>Гүйцэтгэлийн аудит</b>
<b>ГСА</b>	<b>Говьсүмбэр аймаг</b>
<b>ЗДТГ</b>	<b>Засаг даргын Тамгын газар</b>
<b>ЗДҮАХ</b>	<b>Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр</b>
<b>МУЗГ</b>	<b>Монгол Улсын Засгийн Газар</b>
<b>НТШ</b>	<b>Нээлттэй тендер шалгаруулалт</b>
<b>ОНӨААТҮГ</b>	<b>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</b>
<b>ОНӨАГ</b>	<b>Орон нутгийн өмчийн газар</b>
<b>ТАБ</b>	<b>Төрийн аудитын байгууллага</b>
<b>ТАХ</b>	<b>Төсөл, арга хэмжээ</b>
<b>ТЕЗ</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>
<b>ТТ</b>	<b>Техникийн тодорхойлолт</b>
<b>ТЭЗҮ</b>	<b>Техник эдийн засгийн үндэслэл</b>
<b>ҮАХ</b>	<b>Үйл ажиллагааны хөтөлбөр</b>
<b>ХБТХОХ</b>	<b>Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс</b>
<b>ХА</b>	<b>Харьцуулалтын арга</b>
<b>ХАА</b>	<b>Худалдан авах ажиллагаа</b>
<b>ШХА</b>	<b>Шууд худалдан авалт</b>
<b>ЭЗНХҮЧ</b>	<b>Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл</b>

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг

**Аудитын хамарсан хүрээ:**

үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”

- Барилга, байгууламжийн батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

**Аудитын арга зүй:**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, гүйцэтгэлийн хянасан, зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, аймгийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар зэрэг холбогдох бусад байгууллагыг хамруулан, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

**Хүндрэл бэрхшээл:**

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлүүлж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлээ.

**ҮНДСЭН  
МЭДЭЭЛЭЛ**

Аймгийн ИТХ-ын 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор Орон нутгийн төсвийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг 6,263.8 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнээс шинээр хэрэгжих 5,733.1 сая төгрөгийн 25, шилжих 530.7 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг тус тус баталжээ.

Тайлант хугацаанд шинээр хэрэгжих 392.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 5,341.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээг 5,129.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, худалдан авах ажиллагаанаас 211.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

ХАА-нд мөрдсөн журмыг авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтаар 4,915.4 сая төгрөгийн 11, харьцуулалтын аргаар 701.7 сая төгрөгийн 11, шууд худалдан авалтаар 116.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

### Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	08
Хүснэгт 2	Зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй ТАХ	10
Хүснэгт 3	Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, тухайн шатны төсөөт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй ТАХ	10
Хүснэгт 4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон ТАХ	12
Хүснэгт 6	Төсвийн тодотголоор нэмэгдсэн ТАХ	12
Хүснэгт 7	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт 8	Данс бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	18

### Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Усан спорт сургалтын төвийн засварын ажил	16
Зураг 2	Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил	17
Зураг 3	Шивээговь суманд хүүхдийн тоглоомын талбай барих ажил	17
Зураг 4	Халдвартын эмнэлгийн их засварын ажил	17

## БҮЛЭГ 1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

**1.1. ОНХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь бодлогын зорилтод нийцэж байгаа боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй бүрэн нийцээгүй, ТАХ-г шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж эрэмбэлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.**

Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup>.2.5<sup>1</sup>, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3<sup>2</sup>-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ нь аймгийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байх зохицуулалттай байна.

Аймгийн ИТХ-ын 2025.07.28-ны өдрийн 02 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар 6,263.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг баталсан. Уг жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй 77 хувь нь нийцсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Хүснэгт №1							(сая төгрөгөөр)
№	Бодлогын баримт бичгийн нэр	Нийцсэн ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Нийцээгүй ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Нийцсэн байдал хувиар	
1	Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	29	5,887.9	4	376.0	88.0%	
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2025 оны жилийн эцэс	29	5,887.9	6	376.0	88.0%	
3	Говьсүмбэр аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	23	5,661.3	10	602.5	57.0%	
							Дундаж-77.0%

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй 57 хувь нь нийцсэн байна.

Үүнд жилийн хөгжлийн төлөвлөгөөнд өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалт болон авто замын ажлын зураг төсөв боловсруулах арга хэмжээг төлөвлөөгүй нь нөлөөлсөн байна. Тус арга хэмжээнүүд нь бодлогын зорилтуудтай агуулгын хувьд нийцсэн боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй байх тул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүрэн төлөвлөх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

<sup>1</sup> 29<sup>1</sup>.2.5.тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдан байх.

<sup>2</sup> 6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.1</sup><sup>3</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2.1.3<sup>4</sup>, 2.2.2<sup>5</sup>, 2.3.1.1<sup>6</sup>, 2.3.2.1<sup>7</sup>-т орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөхөөр тодорхой заасан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг байгууллагуудаас авсан боловч дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөөгүй, хөрөнгийн ашиглалттай холбоотой зардлын тооцооллыг хийгээгүй байна.

Энэ нь эдийн засгийн болон нийгмийн ач холбогдол багатай, үр дүнгүй төсөл, арга хэмжээ батлагдах үр дагавартай байна. Өмнөх аудитаар дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн боловч хэрэгжээгүй тул Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **1.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй 8 төсөл, арга хэмжээ баталсан байна.**

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>8</sup>, 29 дүгээр зүйлийн 29<sup>1.2.1</sup><sup>9</sup>, 29<sup>1.2.2</sup><sup>10</sup>, 29<sup>1.2.4</sup><sup>11</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 3.2<sup>12</sup>-т заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Гэвч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй 5, газар эзэмших эрхгүй 1, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 2 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд:

### **Газар эзэмших эрхгүй 1 ТАХ:**

<sup>3</sup> 29<sup>1.1</sup>. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

<sup>4</sup> 2.1.3. Төсөл, арга хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах санал боловсруулах;

<sup>5</sup> 2.2.2. Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

<sup>6</sup> 2.3.1.1. тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх;

<sup>7</sup> 2.3.2.1. орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

<sup>8</sup> 4.1.24. “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

<sup>9</sup> 29<sup>1.2.1</sup>. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

<sup>10</sup> 29<sup>1.2.2</sup>. барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

<sup>11</sup> 29<sup>1.2.4</sup>. урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

<sup>12</sup> 3.2. Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага;

1. Шинээр баригдах Найрамдал хотхоны гадна цахилгаан хангамжийн бкв-ын ЦДКШ болон 2\*30 КВА чадалтай хаалттай-335.3 сая төгрөгийн өртөгтэй /122.6 сая төгрөгийн шилжих ажил/

**Зураг төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй ТАХ:**

**Хүснэгт 2**

(сая төгрөгөөр)

№	ТАХ-НИЙ НЭР	Төсөвт өртөг	Хэрэгжсэн эсэх
1	Найрамдал хотхоны 1, 15 дугаар байрны дундах тоглоомын талбай, тохижилтын ажил	158.1	Гэрээ цуцалсан.
2	Шивээговь сумын 8 дугаар байрны техникийн давхарын шугамын ажил	120.0	Хэрэгжсэн
3	Шинээр баригдах орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн ажил (1-р байршил)	300.0	ХАА амжилтгүй болсон
4	Халдвартын эмнэлгийн их засварын ажил	550.0	Хэрэгжсэн
5	Хуучин хүүхдийн эмнэлгийн барилгыг албан конторын зориулалтаар засварлах ажил	480.0	Хэрэгжсэн
<b>Нийт</b>		<b>1,608.1</b>	

(Эх сурвалж: Аудитын судалгаа)

**Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй 2 ТАХ:**

**Хүснэгт 3**

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Монгол гэрийн халаалтын багц худалдан авах	37.0	Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй.
2	Газрын төлөв байдлын чанарын төлөвлөгөөт хянан баталгаажуулалтын ажил	80.0	Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй. /хөрөнгийн зардал бус/
<b>Нийт</b>		<b>117.0</b>	

(Эх сурвалж: Аудитын судалгаа)

Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээ өмнөх оноос 5-аар буюу 248.5 сая төгрөгөөр буурсан боловч зөрчил бүрэн арилаагүй байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>13</sup>, 29 дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.2.1<sup>14</sup>, 29<sup>1</sup>.2.2<sup>15</sup>, 29<sup>1</sup>.2.4<sup>16</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3<sup>17</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,

<sup>13</sup> 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

<sup>14</sup> 29<sup>1</sup>.2.1.тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

<sup>15</sup> 29<sup>1</sup>.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

<sup>16</sup> 29<sup>1</sup>.2.4.урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

<sup>17</sup> 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 3.2<sup>18</sup>, 3.2.2.1<sup>19</sup>, 3.2.2.2<sup>20</sup>, 4 дүгээр зүйлийн 4.10.1.1<sup>21</sup>-т заасныг тус тус зөрчсөн байна.

Өмнөх аудитаар хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байх тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

## БҮЛЭГ 2

**Зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг бодитой тооцож төлөвлөөгүй нь худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл учруулж байна.**

### 2.1 Тендер шалгаруулалтын аргыг хуульд нийцүүлэн сонгосон боловч зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, төсөвт өртгийг бодитой тооцож батлуулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3<sup>22</sup>-т заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас 10 хоногийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах зохицуулалттай бөгөөд хуулийн хугацаанд багтааж ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна.

#### Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл:/сая.төг/

Хүснэгт 4.

(сая төгрөгөөр)

Худалдан авах ажиллагааны арга	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
	ТАХ тоо	Төсөвт өртөг	Тоо	Гэрээ байгуулсан	ТАХ тоо	Хэмнэлт
Нээлттэй тендер шалгаруулалт	11	4,915.4	10	4,450.3	1	465.2
Харьцуулалтын арга	11	701.7	9	573.4	2	128.3
Шууд худалдан авалт	3	116.0	3	106.1	0	9.9
<b>НИЙТ</b>	<b>25</b>	<b>5,733.1</b>	<b>22</b>	<b>5,129.8</b>	<b>3</b>	<b>603.4</b>

(Эх сурвалж: ТЕЗ-ийн ХАА-ны тайлан, Аудитын судалгаа)

Шинээр хэрэгжих 392.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 5,341.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээг 5,129.7 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, худалдан авах ажиллагаанаас 211.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Худалдан авах ажиллагааны 97.9 хувийг цахимаар, 85.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан нь төрийн болон орон нутгийн өмчийн

<sup>18</sup> 3.2.Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага:

<sup>19</sup> 3.2.2.1.эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх

<sup>20</sup> 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

<sup>21</sup> 4.10.1.1.захиалагч нь их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг энэ журмын 8 болон 12 дугаар хавсралтад заасан маягтын дагуу мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргах бөгөөд их засварын ажлын зураг төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна

<sup>22</sup> 44.3.Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ.

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан тэгш боломжтой, ил тод байх зарчимд нийцсэн байна.

**Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон ТАХ:**

Хүснэгт 5.

ТАХ-ний нэр	ХАА-ны арга	Төсөвт өртөг (сая төгрөг)	(сая төгрөгөөр) Дүнд эзлэх хувь (мөнгөн дүнгээр)
Шинээр баригдах орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн ажил (1-р байршил)	НТШ	300.0	77%
Монгол гэрийн халаалтын багц худалдан авах	ХА	37.0	9%
Шинээр баригдах амины болон нийтийн орон сууцны барилгын дэд бүтцийн /инженерийн болон цахилгаан хангамж/ ажлын зураг, төсөв	ХА	55.0	14%
<b>НИЙТ</b>		<b>392.0</b>	<b>100%</b>

(Эх сурвалж: ТЕЗ-ийн ХАА-ны тайлан, Аудитын судалгаа)

Худалдан авах ажиллагааны газраас төсөл, арга хэмжээний худалдан авалтын аргыг хуульд нийцүүлэн сонгож, зохион байгуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1<sup>23</sup>-т заасны дагуу худалдан авах ажиллагааг 05 сарын 31-ний дотор зохион байгуулж дуусгах хуулийн зохицуулалттай бөгөөд 1,481.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гэрээг 05 сарын 31-ний өдрөөс хойш байгуулсан байна. Үүнээс 1,233.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ нь 2025.07.28-ны өдрийн төсвийн тодотголоор нэмэгдсэн байна.

**Төсвийн тодотголоор нэмэгдсэн ТАХ:**

Хүснэгт 6.

(сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг* /сая.төг/	Тендер		
		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Зарласан огноо	Зарцуулсан хугацаа /хоноогоор/
Шинээр баригдах орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн ажил (1-р байршил)	300.0	2025.08.05	2025.08.07 2025.09.17	76
Шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил (1-р байршил)	790.0	2025.08.05	2025.08.15	26
Төмөр замын гармаас Цагдаагийн хэлтэс хүртэлх авто замын зураг, төсөв	40.0	2025.01.10	2025.08.07	27
Шинээр баригдах амины болон нийтийн орон сууцны барилгын дэд бүтцийн /инженерийн болон цахилгаан хангамж/ ажлын зураг, төсөв	55.0	2025.12.03	2025.12.05	11
4 замын уулзвараас хэлмэгдэгсдийн хөшөө хүртэлх талбайн тохижилтын ажил	15.0		ШХА	0
Зураг, төсөв шинэчлэх	33.0		ШХА	0
<b>Нийт</b>	<b>1,233.0</b>			

<sup>23</sup> 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

(Эх сурвалж: ТЕЗ-ийн ХАА-ны тайлан, Аудитын судалгаа)

Цаашид эх үүсвэр нь батлагдсан төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1<sup>24</sup>-т заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг захиалагч батлах, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>25</sup>-т заасны дагуу захиалагч техникийн тодорхойлолтод холбогдох норм, стандарт, дүрэм, зааврыг тусгах хуулийн зохицуулалттай байна.

ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээний ТББ-ийг үнэлгээний хороо боловсруулж захиалагчаар батлуулсан байна. Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолттой холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- УСДУ ОНӨААТҮГ-т экскаватор худалдан авах ажлын тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод даацыг 60тн-оос багагүй гэж заасан боловч тэвшний хэмжээг  $9.6\text{м} \times 2.5\text{м} \times 1.5\text{м} = 36\text{м}^3$  гэж заажээ. Тэвшний хэмжээгээр тооцож үзвэл 30 тн хүртэл даацтай байх боломжтой байна. Авто тээврийн хэрэгслийн ангилал, техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2025 стандартад нэг тэнхлэгт 11.5 тонн нийт 44 тонноос хэтрэхгүй байхаар заасан боловч 60 тонн даацтай байхаар төлөвлөжээ.
- Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлын багц-2 төсөвт өртгийг 195.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд тендерт 5 оролцогч оролцож тус ажлыг 35.1-156.0 сая төгрөгөөр гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн байна. 35.1 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Ашидбуян” ХХК Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5<sup>26</sup>-т заасны дагуу үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлсэн боловч бараа бүрээр ашиглалтын заавар, баталгаат орчуулга ирүүлээгүй шалтгаанаар хасагдаж 156.0 сая төгрөгөөр “Сүвэн уул” ХХК-г шалгаруулсан байна. Захиалагч төсөвт өртгийн зөрүүг харгалзан үзэж гүйцэтгэгч “Сүвэн Уул” ХХК-тай 53.4 сая төгрөгөөр гэрээг байгуулсан байна.
- Усан спорт сургалтын төвийн засвар, өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажлуудад техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан.
- Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засварын нэмэгдэл ажилд гадна фасадны ажлын тоо хэмжээг дутуу тооцсонтой холбоотой 68.0 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.

Захиалагч зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа бодит нөхцөл байдлыг үнэлж судлаагүй, холбогдох дүрэм, журмыг

<sup>24</sup> 11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

<sup>25</sup> 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

<sup>26</sup> 21.5.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын оролцогч тендерийн үнийг төсөвт өртгийн 80 хувиас доош үнэ санал болгох бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

үндэслээгүй, зах зээлийн үнийн судалгааг бодитой хийгээгүй нь худалдан авах ажиллагааны үр ашигтай байх зарчимд нийцээгүй байна.

Иймд захиалагчид төсөвт өртгийг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн бодитой тогтоож баримтжуулах, шаардлагатай тохиолдолд оролцогчдоос ТБОНӨХБАҮХАТХ-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу дээж ирүүлэхийг шаардах, техникийн тодорхойлолт боловсруулахдаа бодит нөхцөл байдлыг үнэлж ажлын тоо хэмжээг тендерийн баримт бичигт үнэн зөв тусгах худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

## **Б.2 Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авсан байна.**

Худалдан авах ажиллагаатай холбоотой 2 гомдлыг тендерт оролцогчдоос Сангийн яаманд гаргасан бөгөөд 1 оролцогч гомдлоо буцаасан бол 1 гомдлыг үндэслэлтэй гэж үзэн тендер шалгаруулалтыг дахин хянах зөвлөмж хүргүүлсэн бөгөөд гомдол гаргасан этгээдтэй гэрээ байгуулсан байна.

## **БҮЛЭГ В**

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 66.7 хувьтай хэрэгжсэн байна.

## **В.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна.**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2 дугаар зүйлийн 2.3.2.4<sup>27</sup>, 4.8.12<sup>28</sup>-т санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгохоор заасан.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинэ болон шилжих 29 төсөл, арга хэмжээнд 5,928.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 4,032.1 сая төгрөгийг 20 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгосон байна. Мөн өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 7 төсөл, арга хэмжээнээс /шилжих ажилд тусгахгүй 1 ТАХ-г төлөвлөсөн/ 5 төсөл, арга хэмжээг тайлант хугацаанд бүрэн гүйцэтгүүлж хүлээн авсан бөгөөд үүний 2 нь 2021, 2022 онд гэрээ байгуулсан ТАХ байна.

## **Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл:**

Хүснэгт 7.

(сая төгрөгөөр)

<sup>27</sup>2.3.2.4.төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх;

<sup>28</sup> 4.8.12.Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:

Төсөл, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөсөн ТАХ	Хүлээн авсан ТАХ	Гүйцэтгэл хувь
Шилжих хөрөнгө оруулалт	530.7	358.1	172.6	67.5%	8	5	63%
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	3,075.4	1,827.9	1,247.5	59.4%	10	5	50%
Их засвар	1,498.0	1,197.0	315.5	79.9%	4	4	100%
Тоног төхөөрөмж	876.7	617.9	239.6	70.5%	4	3	75%
Зураг төсөв	283.0	31.1	251.9	11.0%	7	5	71%
<b>Нийт</b>	<b>6,263.8</b>	<b>4,032.1</b>	<b>2,227.2</b>	<b>64.3%</b>	<b>33</b>	<b>22</b>	<b>66.7%</b>

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын баримт, дансны хуулга, аудитын судалгаа)

Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан 22 төсөл, арга хэмжээнээс төсвийн орлого тасарч санхүүжилтийг зогсоосон тул 11 төсөл, арга хэмжээний 760.0 сая төгрөгийг 2026 онд олгохоор шилжих ажилд батлуулжээ.

Санхүүжилтийг олгохдоо байгуулсан гэрээ болон бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч дараах алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

1. Өмнөх оноос шилжих болон дараа онд шилжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийг 360.4 сая төгрөгөөр илүү баталсан.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас хийх 899.6 сая төгрөгийн гүйлгээг хөгжлийн сангийн данснаас андуурч хийсэн.
3. УСДУ ОНӨААТҮГ-т дугуйт экскаватор худалдан авах ажлын барьцаа хөрөнгө 17.4 сая, алданги 1.7 сая төгрөгийг холбогдох дансуудад шилжүүлээгүй, ерөнхий орлогын дансанд тус тус төвлөрүүлж, баталгаат хугацаа дуусахад олгох мөнгөн хөрөнгийг барьцаа дансанд байршуулаагүй.

Дээрх зөрчлийг аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар илрүүлж зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

Тайлант хугацаанд 4,507.5 сая сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 төсөл, арга хэмжээг хүлээн авч Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын дагуу гэрээг дүгнэжээ.

Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 33 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 22 нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж 66.7 хувьтай биелсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтэд улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зогсоосон, төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын ажил батлахдаа он дамжин хэрэгжих байдлаар бус тухайн жилдээ хэрэгжүүлэхээр баталснаас дулааны улиралд ажил гүйцэтгэх шаардлага үүсч он дамждаг байдал нөлөөлсөн байна.

Цаашид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3<sup>29</sup>-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээтэй холбоотой дараах зөрчил илэрсэн.

<sup>29</sup> өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

### Усан спорт сургалтын төвийн засварын ажил-: 397.9 сая

1. Ашиглагч байгууллагын саналаар ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтод тусгасан гадна налуу зам, хаяавчны ажлын тоо хэмжээг, агааржуулалтын мотор угсарч суурилуулах ажилд шилжүүлж өөрчлөлт оруулсан. Мөн цонхны тавцан чулуун хавтангаар төлөвлөсөн боловч хуванцар тавцан ашигласан.
2. Ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж хаяавчны ажлыг хассан нь борооны улмаас ус нэвчих, фасадны дотор талд цанталт үүсэх, бэхэлгээний төмөр эд ангиуд зэвэрч ашиглалтын хугацаа богиносох зэрэг сөрөг үр дагавартай тул фасадны амыг дарж хаяавчны ажлыг хийх шаардлагатай байна. Мөн барилгад суурилуулсан цонхнууд дотор талдаа нүдэнд үзэгдэх механик үйлчлэл байхгүй боловч хагарсан. Агааржуулалт хангалтгүй, конденсаци үүссэнээс хөгц мөөгөнцөр үүссэн байна.

Зураг 1.



### Өгөөж захын уулзвараас 2 дугаар сургуулийн уулзвар хүртэлх авто замын ажил- 998.8 сая

1. Замын трасст мэдээлэл холбооны сүлжээний шилэн кабель таарсан тул холбооны шилэн кабелийг сувагчлах, хүчитгэх шаардлага гарсан байна. Уг ажлын төсөвт өртөг 121.8 сая төгрөгийг замын трассыг өөрчилсөнтэй холбоотой хэмнэлт 95.1 сая, магадлашгүй ажлын зардал 17.5 сая төгрөгөөс гүйцэтгэжээ. Ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотой төсвийг боловсруулж, зураг төсөв зохиогч, захиалагч, гүйцэтгэгч байгууллагуудтай зөвшилцсөн бөгөөд өөрчлөлт оруулсан тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.
2. Авто замын тэмдэг тэмдэглэгээнүүд хөдөлгөөнд орж хазайсан, ус цуглуулах талбайд анхааруулах тэмдэг байршуулаагүй.

Зураг 2.



**Шивээговь суманд хүүхдийн тоглоомын талбай барих ажил:**

Гүйцэтгэгч компани захиалагчтай зөвшилцөлгүйгээр сагсны талбайг зориулалтын РТЕ хуванцар шалаар хийх байсныг өөрчлөн резинин будгаар будсан байна. Дээрх үнийн зөрүүгээр гадна камержуулалт, тоглоомын талбайд хиймэл зүлэг хийлгэсэн боловч төсөвт өртгийн зөрүүг тооцож баталгаажуулаагүй. Сагсны хашаа зарим хэсгээрээ урагдаж ханзарсан, сүүдрэвчийн дээврийн хар цаас салхинд урагдаж хийссэн, резинин будаг халцарсан байна.

Зураг 3.



**Халдвартын эмнэлгийн их засварын ажил-544.9 сая**

Техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд 5.6 сая төгрөгийн өртөгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу зам, бариул зэргийг хийж гүйцэтгээгүй.

Зураг 4



Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3<sup>30</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2<sup>31</sup>, Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.6<sup>32</sup>, 8 дугаар зүйлийн 8.1<sup>33</sup>, 8.2.2<sup>34</sup>-т заасныг тус тус зөрчсөн тул захиалагч байгууллагад зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **В.2 Ашиглалтад хүлээн авсан 532.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг НББ-д бүртгэж тайлагнаагүй байна.**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2<sup>35</sup>, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>36</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>37</sup>, Засгийн газрын 2023 оны 278-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1<sup>38</sup>-т заасны дагуу ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнах хуулийн зохицуулалттай байна.

Тайлант хугацаанд 4,507.5 сая сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авснаас 3,974.9 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд бүртгэсэн байна.

### **Данс бүртгэлд тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт:**

Хүснэгт 8.

(сая төгрөгөөр)

№	ТАХ-ний нэр	Гэрээний дүн	Хүлээн авсан актын огноо
1	Усан спорт, сургалтын төвийн засварын ажил	397.9	2025.10.06 2025/08
2	РП барих зураг, төсөв боловсруулах ажил	30.9	2025.11.28 09/2025
3	Амрах байрны уулзвараас УБТЗ ХНН-ийн халуун ус хүртэлх 800м, Тээвэрчдийн байрнаас Хорихын 75 айлын орон сууц хүртэлх авто замын ажлын зураг төсөв	24.0	2025.11.12 №04
4	Төмөрзамын гармаас Цагдаагийн хэлтэс хүртэлх авто замын зураг, төсөв	38.0	2025.12.08 №05
5	Зураг, төсөв шинэчлэх /шинээр баригдах ОСХ-ын инженерийн шугам сүлжээний салбар шугамын зураг төсөв/	23.4	2025.12.02 СЕЕ-14/2025
6	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх зураг төсөв	18.4	2025.11.27 ГСАОНӨГ/202112011
<b>Нийт</b>		<b>532.6</b>	

(Эх сурвалж: Аудитын судалгаа)

<sup>30</sup> 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

<sup>31</sup> 26.4.2.санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

<sup>32</sup> 7.6. Комисс ажилласаны дараа комиссын гишүүд өгсөн санал, үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, биелэлт хангагдсан тохиолдолд энэ дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулна.

<sup>33</sup> Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.

<sup>34</sup> 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт

<sup>35</sup> 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

<sup>36</sup> 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

<sup>37</sup> 6.2.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

<sup>38</sup> 5.5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ

Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй нь хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна. Иймд дээрх хөрөнгийг бүртгэлжүүлэх албан шаардлагыг захиалагч болон Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитаар нийт 2,380.2 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 2,380.2 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг **2026 оны 11 дүгээр сарын 16-**ны өдрийн дотор ирүүлэх, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу **тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор** тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

## ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Орон төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 66.7 хувьтай хэрэгжсэн байна.

### **Бүлэг-1**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

1. ОНХО-р хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь бодлогын зорилтод нийцэж байгаа боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй бүрэн нийцээгүй, ТАХ-г шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж эрэмбэлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн байна
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй 8 төсөл, арга хэмжээ баталсан байна

### **Бүлэг-2**

Зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг бодитой тооцож төлөвлөөгүй нь худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл учруулж байна.

1. Тендер шалгаруулалтын аргыг хуульд нийцүүлэн сонгосон боловч зарим төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, төсөвт өртгийг бодитой тооцож батлуулаагүй байна.
2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хянасан шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авсан байна.

### **Бүлэг-3**

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 66.7 хувьтай хэрэгжсэн байна.

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байна.
2. Ашиглалтад хүлээн авсан 532.6 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг бүртгэж тайлагнаагүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Захиалагч буюу аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаатарт:

1. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүрэн тусгах
2. Төсөвт өртгийг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн бодитой тогтоож баримтжуулах, шаардлагатай тохиолдолд оролцогчдоос ТБОНӨХБАҮХАТХ-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу дээж ирүүлэхийг шаардах, техникийн тодорхойлолт боловсруулахдаа бодит нөхцөл байдлыг үнэлж ажлын тоо хэмжээг тендерийн баримт бичигт үнэн зөв тусгах

# ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Найрамдал хотгон, 3 дугаар баг  
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015  
Утас/Факс: (976) 7054 3005  
Цахим шуудан: zdtg\_gsa@gmail.com  
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2026.05.11 № 8/11  
танай \_\_\_\_\_ -ний № \_\_\_\_\_ -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА  
ТАНАА

Орон нутгийн төсвийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал байхгүй болно.

ОРЛОГЧ ДАРГА



Б.НАРАНБААТАР

Ассистент  
Аудитор  
Б. Дарханбаатар  
Аудитын тайлан  
Төсөлд санал байхгүй болно  
2026.05.11

Хавсралт №1

Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй  
төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөвт өртөг
				Эхлэх	Дуусах	
1	Ус-Ду ОНӨААТҮГ азарт дугуйт экскаватор худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	350.0
2	Ус-Ду ОНӨААТҮГ азарт нүүрс тээврийн чиргүүл худалдан авах	Тоног төхөөрөмж	Шинэ	2025	2025	85.0
3	Амрах байрны уулзвараас УБТЗ ХНН-ийн халуун ус хүртэлх 800м, Тээвэрчдийн байрнаас Хорихын 75 айлын орон сууц хүртэлх авто замын ажлын зураг төсөв боловсруулах	Зураг төсөв	Шинэ	2025	2025	25.0
4	4 замын уулзвараас хэлмэгдэгсдийн хөшөө хүртэлх талбайн тохижилтын ажил	Зураг төсөв	Шинэ	2025	2025	15.0
5	Төмөрзамын гармаас Цагдаагийн хэлтэс хүртэлх авто замын зураг, төсөв	Зураг төсөв	Шинэ	2025	2025	40.0
6	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх зураг төсөв	Зураг төсөв	Шилжих	2021	2025	9.2
7	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	Зураг төсөв	Шилжих	2022	2025	6.7
8	Сүмбэр сумын 1 болон 5 дугаар сургуулийн сурагчдын бие засах өрөөний засварын ажил	Их засвар, тохижилт	Шилжих	2024	2025	41.5
9	Политехникийн коллежийн дотуур байрны их засварын ажлын зураг төсөв боловсруулах ажил	Зураг төсөв	Шилжих	2024	2025	11.8
10	Худалдаачны гудамжны үлдэгдэл ажил	Их засвар, тохижилт	Шилжих	2024	2025	18.4
<b>Нийт</b>						<b>602.6</b>